

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ШИЙДВЭР

Огноо: 2022.11.09

№ 22/06

Улаанбаатар хот

Компанийн дүрмэнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.3, 62-р зүйлийн 62.1.1, 62.1.6, Банкны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.1 дэх заалт, 2022 оны 11 дугаар сарын 09-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. Компанийн дүрмэнд дараах өөрчлөлтийг оруулсугай. Компанийн дүрмийн 4.2 дугаар зүйл *“Хувьцаа эзэмшигчдийн худалдан авч эзэмшсэн буюу эргэлтэд гаргасан хувьцааны нэрлэсэн үнийн дүнгээс Банкны хувь нийлүүлсэн хөрөнгө бүрдэнэ. Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь нэг бүрийн 1,600 төгрөгний нэрлэсэн үнэтэй 62,500,000 (жаран хоёр сая таван зуун мянган) ширхэг энгийн хувьцаанаас бүрдэх 100,000,000,000 (нэг зуун тэрбум) байна. Банк нь хуульд заасан журмын дагуу хувьцааны хувь хэмжээ, үнэ дүнг өөрчилж болно.”* байсныг **4.2 Хувьцаа эзэмшигчдийн худалдан авч эзэмшсэн буюу эргэлтэд гаргасан хувьцааны нэрлэсэн үнийн дүнгээс Банкны хувь нийлүүлсэн хөрөнгө бүрдэнэ. Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь нэг бүрийн 80 төгрөгний нэрлэсэн үнэтэй 1,250,000,000 (нэг тэр бум хоёр зуун тавин сая) ширхэг энгийн хувьцаанаас бүрдэх нийт 100,000,000,000 (нэг зуун тэрбум) төгрөг байна. Банк нь хуульд заасан журмын дагуу хувьцааны хувь хэмжээ, үнэ дүнг өөрчилж болно.** гэж өөрчлөв. Компанийн дүрмийг шийдвэрийн Нэгдүгээр хавсралтаар баталсугай.

Хоёр. Компанийн хувьцааг хуваах зорилго, үндэслэл, хувьцаа хуваах ажлыг гүйцэтгэх журмыг тусгасан “Хувьцаа хуваах төсөл”-ийг шийдвэрийн Хоёрдугаар хавсралтаар баталсугай.

Гурав. Компанийн дүрмийн нэмэлт өөрчлөлтийг баталсантай холбоотойгоор Улсын бүртгэлд бүртгүүлэх, Санхүүгийн Зохицуулах хороо, Монголбанкинд тус тус хүргүүлэх ажиллагааг хийх, холбогдох баримт бичгийг үйлдэх, “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК, Санхүүгийн зохицуулах хороонд үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах тухай хүсэлт гаргах, бүртгүүлэх, зөвшөөрөл авах эрхийг “Богд Банк”ХК-ийн гүйцэтгэх захирал Г.Саруул-д даалгасугай.

Дөрөв. Энэхүү ээлжит бус хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийг холбогдох эрх бүхий байгууллагад хүргүүлж нийтэд мэдээлэхийг “Богд Банк” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга Р.Нямцэрэн- үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Л.БОЛДХУЯГ